



## ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 07 сарын 28 өдөр

Дугаар A/166

Улаанбаатар хот

### Дүрэм батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.19-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Захиргааны удирдлагын газар /хурандаа Л.Болдбаатар/, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга /хурандаа Ж.Чүлтэмсүрэн/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны А/799 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2021 оны 07 дугаар сарын 16 ны өдрийн  
А/166 дугаар тушаалын хавсралт



## ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

### Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрэм нь Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд оршино.

1.2. Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын хэмжээнд энэхүү дүрмийг дагаж мөрдөж, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлж ажиллана.

1.3. Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай, Гамшгаас хамгаалах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Цэргийн нийтлэг дүрмүүд, бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг ёс зүйн зөрчилд тооцно.

### Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэхүү дүрэм нь Онцгой байдлын байгууллагад төрийн тусгай албан тушаал эрхэлж байгаа алба хаагч, байгууллагын захиалгаар гадаад дотоодын их, дээд сургуульд суралцаж байгаа сонсогч, суралцагч нарт хамаарна.

### Гурав. Ёс зүйн зарчим

3.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь үйл ажиллагаандаа дор дурдсан ёс зүйн зарчмыг баримтална.

- Ёс зүйг дээдлэн-Манлайлагч байх;
- Хуулийг дээдлэн-Хэрэгжүүлэгч байх;
- Шударга ёсыг сахиж-Шуурхай байх;
- Тэгш байдлыг хангаж-Хүртээмжтэй байх;
- Ил тод байж-Хариуцлага хүлээх;

### Дөрөв. Ёс зүйн эрхэмлэн дээдлэх зүйл

4.1 Онцгой байдлын байгууллагын алба хаагч, ажилтан нь энэ дүрмийн 3.1-т заасан зарчмын хүрээнд төрийн бодлого, байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг үзүүлэхдээ дор дурдсан зүйлсийг эрхэмлэн дээдэлнэ.

#### 4.1.1. Ёс зүйг дээдлэн-Манлайлагч байх зарчмын хүрээнд:

Төрийн алба хаагчийн нэр хүнд, сахилга хариуцлага, ёс зүйг дээдлэн, өөрийн мэдлэг, ур чадвараа байнга хөгжүүлж, бусдыг манлайлна;

#### 4.1.2. Хуулийг дээдлэн-Хэрэгжүүлэгч байх зарчмын хүрээнд:

Аливаа улс төр, үзэл суртлаас ангид байж, Монгол Улсын Үндсэн хууль болон дагаж мөрдвөл зохих хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа дээдлэн сахиж, төрийн үйлчилгээг зөвхөн хууль тогтоомжид нийцүүлж хүргэнэ;

#### 4.1.3. Шударга ёсыг сахиж-Шуурхай байх зарчмын хүрээнд:

Хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, ашиг сонирхлын аливаа зөрчилд автахгүйгээр зөвхөн нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн чин шударгаар ажиллаж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэнэ;

4.1.4. *Тэгш байдлыг хангаж-Хүртээмжтэй байх зарчмын хүрээнд:*

Байгууллага, аж ахуйн нэгж болон иргэн бүртэй адил тэгш эрхтэй харьцан төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэж, тэдний итгэлийг хүлээж ажиллана;

4.1.5. *Ил тод байж-Хариуцлага хүлээх зарчмын хүрээнд:*

Албан тушаалын тодорхойлолтод заагдсан зорилго, зорилт, чиг үүргийн хүрээнд хариуцсан ажлаа ил тод, нээлттэй (Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжид зааснаас бусад) гүйцэтгэж, гарсан үр дүнгийн төлөө хариуцлага хүлээнэ.

#### Тав. Ёс зүйн хэм хэмжээ

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдаас хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад үйл ажиллагаандаа эрхэмлэвэл зохих зан үйл, ёс суртахууны нийлбэр цогцыг Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн ёс зүйн хэм хэмжээ гэнэ.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн ёс зүй нь албан үүргээ амжилттай гүйцэтгэх үндсэн нөхцөлийн нэг тул алба хаагчдаас ёс зүйн хэм хэмжээг заавал сахин биелүүлэхийг шаардана.

5.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь энэхүү дүрмийн 4.1.1-т заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

5.1.1. Онцгой байдлын байгууллагын нэгдмэл удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа чанд мөрдөж, дээд байгууллага, албан тушаалтнаас хуульд нийцүүлэн гаргасан шийдвэр, үүрэг даалгаврыг ёсчлон биелүүлэх;

5.1.2. Онцгой байдлын байгууллагын нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, байгууллагын хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр оруулах;

5.1.3. өөрийн мэдлэг чадвар, дадал, туршлагаа байнга дээшлүүлж, зөв зан төлөвийг хэвшүүлэн, алдаа дутагдал гаргахгүй байх, сурсан мэдсэн болон ажлын туршлагаа бусдад заан сургаж, зөв үлгэр дуурайлал үзүүлэх;

5.1.4. гэр бүл, үр хүүхдэдээ халамж анхааралтай байж, ёс суртахууны нийтээр зөвшөөрөгдсөн хэм хэмжээг сахиж мөрдөх;

5.1.5. албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөт эм, бэлдмэл хэрэглэх, дүрмийн бус хувцаслах, олон нийтийн газар зүй бус зан авир гаргахыг хориглох;

5.1.6. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээнд төрийн болон албаны нууц, байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчид хамаарах мэдээ, мэдээлэл, албаны дүрэмт хувцастай фото зураг, дүрс бичлэг, санал, сэтгэгдэл байршуулахгүй байх;

5.2. Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь энэхүү дүрмийн 4.1.2-т заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

5.2.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт, байгууллагын хэмжээнд даган мөрдөж байгаа дэг журам, дүрэм, зааврыг чанд сахих;

5.2.2. өргөсөн тангарагтаа үнэнч байж, захирах, захирагдах ёсыг чанд баримтлан Цэргийн нийтлэг дүрмийг чанд мөрдөх;

5.2.3. төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэгдсэн аливаа арга хэмжээ төлөвлөх, зохион байгуулж тэдгээрт оролцох, ажил хаях, жагсаал цуглаан хийх, өлсгөлөн, суулт зарлах зэрэг олон нийтийн болон улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй байж, улс төрийн хувьд төвийг сахиж ажиллах;

5.2.4. хууль зөрчсөн, алба тушаалын байдлаа урвуулан ашигласан болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ

тухай дээд шатны байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;

5.2.5. албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, албаны нэрээр түрүү барих, ашиг хонжоо олох, бусдыг дарамтлах, далайлган сүрдүүлэх, хавчин гадуурхах, эрхшээлдээ байлгахыг хориглох;

5.2.6. бусад алба хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, саад болох, ятгах, зуучлах, аливаа болзол тавих, хууль бус үйлдэл хийхийг шаардах, үүрэг даалгавар өгөхийг хориглох;

5.2.7. алба хаагчид хоорондоо зөв боловсон харьцаж элдэв нэр хоч зүүлгэхгүй, нас хүйс, өнгө зүс, нийгмийн гарал үүсэл, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх;

5.2.8. алба хаагчид жендэрийн эрх тэгш байдлыг хангаж, жендэрт суурилсан хүчирхийлэл үүсгэхгүй байх;

5.3. Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь энэхүү дүрмийн 4.1.3-т заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

5.3.1. албан тушаал, хуулиар олгосон эрх мэдлээ хувийн зорилгод ашиглах, албан үүргээ биелүүлсэнтэй холбогдуулан бусдаас шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, бусдын нөлөөнд автах, хуульд зааснаас бусад эрх хангамж эдлэхгүй байх;

5.3.2. өөрийн өмчийн байдал, тэдгээрт орсон өөрчлөлт орлогын талаар эрх бүхий байгууллагад үнэн зөв мэдээлэх;

5.3.3. албандаа ямагт чин сэтгэлээс өөриймсөг хандан, ажлын цагийг үр бүтээлтэй, бүрэн дүүрэн ашиглах;

5.3.4. харьяа дээд шатны албан тушаалтныг бодлого боловсруулах, асуудалшийдвэрлэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, үндэслэл бүхий үнэн зөв мэдээ, мэдээллээр хангах;

5.4. Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь энэхүү дүрмийн 4.1.4-т заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

5.4.1. албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөртөө болон хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал үүсгэхгүй байх, иргэд, үйлчлүүлэгч, хамтран ажиллагсадтайгаа адил тэгш, хүндэтгэлтэй харилцаж, хүний хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх;

5.4.2. төрийн үйлчилгээ үзүүлэхдээ аж ахуйн нэгж, байгууллагыг өмчийн хэлбэрээр, алба хаагч, иргэдийг үндэс угсаа, нас, хүйс, хэл, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлахгүй байх;

5.4.3. иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг хууль тогтоомжийн хүрээнд зохих дүрэм, журмын дагуу хүнд суртал гаргахгүй, чирэгдэлгүй шуурхай хүртээмжтэй хүргэх;

5.4.4. найз нөхөд, гэр бүл, төрөл садангийн хүмүүс цуг ажиллаж байгаа тохиолдолд тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, албаны нэр барих, албан тушаалын эрхээ урвуулан ашиглахыг цээрлэх;

5.4.5. алба хаагчид нь албаны мэдлэг, ур чадвар, сахилга хариуцлага, зан байдлаараа иргэд олон нийтийн итгэл, хүндэтгэлийг хүлээж ажиллах;

5.5. Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь энэхүү дүрмийн 4.1.5-д заасан эрхэмлэн дээдлэх зүйлсийн хүрээнд дор дурдсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө:

5.5.1. албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнг бүрэн хариуцах;

5.5.2. удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг урьдчилан анхааруулж байх;

5.5.3. Төрийн болон албаны нууц, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байж, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглах, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараан дэлгэрүүлэхгүй байх;

5.5.4. албан ажилд шаардлагатай мэдээ мэдээлэл, Ёс зүйн алдаа дутагдлыг санаатайгаар нуун дарагдуулах, хуурамчаар үйлдэх, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;

5.5.5. байгууллагын өмч хөрөнгө, техник хэрэгсэл, хувцас хэрэглэл, албан хэрэгцээний баримт бичиг, мэдээллийн санг албаны бус зориулалтаар ашиглахгүй байх;

#### Зургаа. Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх

6.1. Онцгой байдлын байгууллагын алба хаагч ёс зүйн зөрчил гаргасан бол түүний эрхэлж байгаа албан тушаал, цол, ажилласан жил, дадлага туршлагаас үл хамааран Онцгой байдлын ерөнхий газрын даргын томилсон ажлын хэсэг шалган шийдвэрлэнэ.

6.2. Ёс зүй зөрчсөн тухай гомдлыг дараах үндэслэлээр шалгаж шийдвэрлэнэ:

6.2.1. иргэн, албан тушаалтан, байгууллага гомдол, мэдээлэл ирүүлсэн;

6.2.2. Онцгой байдлын ерөнхий газрын даргын шийдвэрээр,

6.3. Онцгой байдлын байгууллагын Ёс зүйн зөвлөлийн ажиллах журмыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга батална.

#### Долоо. Хариуцлага

7.1. Ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчид эрх бүхий албан тушаалтан Цэргийн сахилгын дүрмийн Гуравдугаар бүлэгт заагдсан сахилгын шийтгэлийг оногдуулах бөгөөд заавал дэс дараалан хэрэглэх шаардлагагүй.

7.2. Ёс зүйн зөрчил гаргаж сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагчийг Цэргийн сахилгын дүрмийн 42, 43-т заасны дагуу сахилгын шийтгэлгүйд тооцож болно.

#### Найм. Бусад

8.1. Энэхүү дүрмийн хэрэгжилтийг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч болон ёс зүйн салбар зөвлөлийн гишүүд хангаж ажиллана.

8.2. Дотоод хяналт шалгалтын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, Захиргааны удирдлагын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд хяналт тавьж ажиллана.